



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2018.04.03 № 17

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
САЙД Д.СУМЪЯАБАЗАР ТАНАА

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33.1.2-т заасан бүрэн эрхийнхээ дагуу Төр, нийгмийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзэж доорх асуудлаар асуулга тавьж, түүний хариуг хуулийн дагуу УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр Танд хандаж байна.

Таныг Засгийн газрын гишүүн, сайдаар томилох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн УИХ-ын нэгдсэн чуулганы худалдаан дээр МАН-аас 2016 оны сонгуульд дэвшүүлэн оролцсон мөрийн хөтөлбөрийн 2.4.4,-2.4.5 дахь заалтын хэрэгжилтийг тодорхой зохион байгуулах, "Монгол хүн эх орныхоо газар нутаг, газрын баялагтаа эзэн байх боломжийг хангах зарчим барьж ажиллах"-ыг чиглэл болгож байсан. Ялангуяа Оюу-Толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ, Дубайн гэрээний үр дагавар, өгөөжийг үнэлж дүгнэн, ард иргэддээ улирал бүр тогтмол тайлагнаж ажиллахыг онцлон дурдсан байна. Энэ байдлаас дүгнэлт хийж дараахь асуулгыг тавьж байна. Үүнд;

1.Оюу-Толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ болон хувь нийлүүлэгчдийн гэрээ, "Оюу-Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө" хэмээх гэрээ нь Монгол Улсын хууль, УИХ-ын болон Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрүүдэд нийцэж байсан эсэхэд дүгнэлт хийсэн үү, Монголын төр, нийгмийн ашиг сонирхолыг хохироосон зүйл заалт, үйлдэл байгаа эсэх.

2. "Оюу-Толгойн хөрөнгө оруулалтын гэрээг эргэж харах, өөрчлөх шаардлагагүй" гэсэн /Үндэсний шуудан сонины 2018-03-23-ны өдрийн 058 дугаарт/ Та бүхний мэдэгдэл Засгийн газрын албан ёсны байр суурь мөн эсэх.

3. Засгийн газрын зүгээс тогтвортой, ашигтай байдлыг хангаж ажиллана гэдгээр "Рио Тинто" компанитай ойлголцож, хамтарч ажиллаж байгаа гэсэн Та бүгдийн мэдэгдлийн хүрээнд чухам ямар бодлого тодорхойлогдсон, ажлын явц, үр дүнг хэрхэн төсөөлж байна вэ?

0000000007

4. Оюу-Толгой ХХК-ийн үр ашгийг иргэн бүрт хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлэх тухай мөрийн хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг хангах талаар ямар тодорхой үйл ажиллагаа явуулж байна. Ажлын эхлэл, ойрын ирээдүйн үр дүнг хэрхэн төсөөлж байгаа вэ?. Энэ зорилтыг Оюу-Толгойн анх байгуулсан хөрөнгө оруулалтын болон бусад гэрээний хүрээнд хэрэгжүүлэх ямар баталгаа байна вэ? Оюу-Толгойн гэрээг эргэж харахгүй байх үндэслэл болохоор УИХ-ын ямар шийдвэр хэзээ гарсан бэ?

5. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Рио-Тинто группын гүйцэтгэх захирал Жан Себастьян Жактай уулзах үеэр ярилцаж Оюу-Толгойн төслийг Монголын ард түмэнд өгөөжтэй байлгах, гүний уурхайн бүтээн байгуулалтыг үр ашигтай хэрэгжүүлэхийн тулд хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллуулахаар тохиролцсон ажлын явц, эхлэл ямар байна вэ? Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамж, чиглэл батлагдсан эсэх.

Газрын доорх баялгаа газрын дээрх баялаг, тухайлбал, хөгжил дэвшил болгох, өр авлага болгочихгүй байх зорилтод хэрхэн анхаарч байна вэ?

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж тодорхой чиглэл гаргуулж дэмжин ажиллах болно.

Таныг хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ч.УЛААН
Д.ТЭРБИШДАГВА
Б.БАТЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2018. 04. 03 № 18

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33.1.2-т заасан бүрэн эрхийнхээ дагуу Төр, нийгмийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзэж доорх асуудлаар асуулга тавьж, түүний хариуг хуулийн дагуу УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр Танд хандаж байна.

Таныг Засгийн газрын гишүүн, сайдаар томилох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн УИХ-ын нэгдсэн чуулганы худалдаан дээр МАН-аас 2016 оны сонгуульд дэвшүүлэн оролцсон мөрийн хөтөлбөрийн 2.4.4,-2.4.5 дахь заалтын хэрэгжилтийг тодорхой зохион байгуулах, “Монгол хүн эх орныхоо газар нутаг, газрын баялагтаа эзэн байх боломжийг хангах зарчим барьж ажиллах”-ыг чиглэл болгож байсан. Ялангуяа Оюу-Толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ, Дубайн гэрээний үр дагавар, өгөөжийг үнэлж дүгнэн, ард иргэддээ улирал бүр тогтмол тайлагнаж ажиллахыг онцлон дурдсан байна. Энэ байдлаас дүгнэлт хийж дараахь асуулгыг тавьж байна. Үүнд;

1.Оюу-Толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ болон хувь нийлүүлэгчдийн гэрээ, “Оюу-Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө” хэмээх гэрээ нь Монгол Улсын хууль, УИХ-ын болон Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрүүдэд нийцэж байсан эсэхэд дүгнэлт хийсэн үү, Монголын төр, нийгмийн ашиг сонирхолыг хохироосон зүйл заалт, үйлдэл байгаа эсэх.

2. “Оюу-Толгойн хөрөнгө оруулалтын гэрээг эргэж харах, өөрчлөх шаардлагагүй” гэсэн /Үндэсний шуудан сонины 2018-03-23-ны өдрийн 058 дугаарт/ Та бүхний мэдэгдэл Засгийн газрын албан ёсны байр суурь мөн эсэх.

3. Засгийн газрын зүгээс тогтвортой, ашигтай байдлыг хангаж ажиллана гэдгээр “Рио Тинто” компанитай ойлголцож, хамтарч ажиллаж байгаа гэсэн Та бүгдийн мэдэгдлийн хүрээнд чухам ямар бодлого тодорхойлогдсон, ажлын явц, үр дүнг хэрхэн төсөөлж байна вэ?

0000000009

4. Оюу-Толгой ХХК-ийн үр ашгийг иргэн бүрт хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлэх тухай мөрийн хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг хангах талаар ямар тодорхой үйл ажиллагаа явуулж байна. Ажлын эхлэл, ойрын ирээдүйн үр дүнг хэрхэн төсөөлж байгаа вэ?. Энэ зорилтыг Оюу-Толгойн анх байгуулсан хөрөнгө оруулалтын болон бусад гэрээний хүрээнд хэрэгжүүлэх ямар баталгаа байна вэ? Оюу-Толгойн гэрээг эргэж харахгүй байх үндэслэл болохоор УИХ-ын ямар шийдвэр хэзээ гарсан бэ?


5. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Рио-Тинто группын гүйцэтгэх захирал Жан Себастьян Жактай уулзах үеэр ярилцаж Оюу-Толгойн төслийг Монголын ард түмэнд өгөөжтэй байлгах, гүний уурхайн бүтээн байгуулалтыг үр ашигтай хэрэгжүүлэхийн тулд хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллуулахаар тохиролцсон ажлын явц, эхлэл ямар байна вэ? Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамж, чиглэл батлагдсан эсэх.

Газрын доорх баялгаа газрын дээрх баялаг, тухайлбал, хөгжил дэвшил болгох, өр авлага болгочихгүй байх зорилтод хэрхэн анхаарч байна вэ?

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж тодорхой чиглэл гаргуулж дэмжин ажиллах болно.

Таныг хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ч.УЛААН
Д.ТЭРБИШДАГВА
Б.БАТЭРДЭНЭ